



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2011 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 986

Улаанбаатар хот

**Төрийн архивын үйл ажиллагааг  
бэхжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн 2011 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаас нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, зарим харьяа газруудын архивын баримтад явуулсан тооллогын нэгдсэн дүн, тэдгээрт хийгдсэн дүн шинжилгээг хэлэлцээд, нийслэлийн архивын салбарын үйл ажиллагааг дэмжиж хуралдаанаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор нийслэлийн Архивын газрын бүтэц, орон тооны хязгаарыг хавсралтад заасны дагуу 3 хэлтэс, 20 хүртэл орон тоотой байхаар шинэчлэн баталсугай.

2. Архив албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж байгууллагуудын үйл ажиллагааны явцад үүссэн эрдэм шинжилгээ, түүх нийгэм, улс төр, эдийн засаг, соёл шинжлэх ухааны ач холбогдолтой бүх төрлийн архивын баримтаар байгууллага болон төрийн архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлж ажлын чанар уялдаа холбоог сайжруулах, баримтын хадгалалт хамгаалалтын зохистой нөхцлийг хангах, мэдээллийн технологийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх, архив, албан хэрэг хөтлөлтийн мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулахыг Нийслэлийн нутгийн захиргааны болон дүүрэг, харьяа газар, аж ахуйн байгууллагуудын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Төрийн архивыг зориулалтын байртай болгох асуудлыг судлан, зохион байгуулалтын арга хэмжээ авч, шийдвэрлэж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч Б.Мөнхбаатарт, архив зүй, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр орон

нутаг дахь салбарын ажилтнуудыг сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар бодлого зохицуулалтын цогц арга хэмжээ авч, дэмжиж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Цогзолмаад, Архивын газрын шинэчлэн батлагдсан орон тоо, цалингийн санг тооцож шаардлагатай зардал санхүүжилтийг шийдвэрлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулж Нийслэлийн Засаг даргын 2009 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 14 дүгээр захирамжийн хавсралтын Архивын газрын бүтэц орон тооны хязгаарыг баталсан 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Г. МӨНХБАЯР

Нийслэлийн Засаг даргын 2011 оны  
*12 дугаар* сарын *19*-ны өдрийн  
*986 дугаар* захирамжийн хавсралт



НИЙСЛЭЛИЙН АРХИВЫН ГАЗРЫН  
БҮТЭЦ, ОРОН ТОО

д/д	Хэлтэс, нэгжийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Орон тоо, зохион байгуулалт.
1	Удирдлага		1
2	Төлөвлөлт, арга зүйн хэлтэс.	Орон нутгийн хэмжээнд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, орон нутгийн түвшинд салбарын үйл ажиллагааны бодлого, төлөвлөлтийг хариуцаж хэрэгжүүлэх.	6 хүртэл
3	Гүйцэтгэл, үйл ажиллагааны хэлтэс.	Төрийн архивыг түүх, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны ач холбогдол бүхий баримтаар нөхөн баяжуулах, сонголт, нягтлан шалгалт хийх, тоо бүртгэл лавлах аппарат хөтөлж баяжуулах, хадгалалт хамгаалалт, ашиглалтын үйл ажиллагааг сайжруулах	11 хүртэл
4	Мэдээллийн технологийн тасаг	Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй баримт, эх сурвалжийн талаарх мэдээллийн эрэлт, хайлт ашиглалтын үйл ажиллагааг түргэн шуурхай болгож, архивын эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан байгуулах, төрийн архив болон нийслэл, орон нутгийн хэмжээнд мэдээллийн технологийг нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	2 хүртэл
<b>Нийт орон тоо</b>			<b>20 хүртэл</b>